


Герман хэлний заах аргын нэгдэл (ГХЗАН)

Дойче шуле сургуулийн ГХЗАН-д 6 монгол 1 гадаад багш ажилладаг ба үүнд магистер зэрэгтэй 2, Герман хэлний “Заах аргач багш” 2 тус бүр байна. Манай багш нар герман хэлний C1- C2 зэргийн хэлний дипломтой бөгөөд герман хэлийг мэргэжлийн өндөр түвшинд заах үр чадвартай хамт олон юм.

Түүнчлэн ХБНГУ-ын засгийн газар болон ZfA, PAD байгууллагаас жил бүр манай сургуулийн 2-3 багшийг 14 хоногоос 1 жилийн хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтанд тогтмол хамруулж багш нарын үр чадварыг сайжруулах тал дээр дэмжин ажилладаг.

Манай багш нар сүүлийн жилүүдэд сурагчидаа A1, A2, ДСД1 болон ДСД 2 шалгалтуудад маш амжилттай бэлдэн оролцуулж байгаа бөгөөд энэ амжилтаараа Монгол улсдаа нэгдүгээрт бичигдэж явна. ГХЗАН-н хамт олон сурагчидаа зөвхөн герман хэлний шалгалтанд сайн бэлдээд зогсохгүй герман хэл дээрх олимпиад, тэмцээн, уралдаанд мөн цаг ямагт сурагчидаа амжилттай оролцуулж байна. Тэдгээрээс онцлох нэг зүйл бол Дойче Шуле сургуулийн төгсөгчид 2010 оноос эхлэн ХБНГУ-д ДААД-н буюу засгийн газрын тэтгэлэгээр суралцах болсон явдал юм. Монгол Улсын хэмжээнд зарлагддаг тус тэтгэлэгт уралдаанд сүүлийн 2 жил дараалан зөвхөн манай сурагчид амжилттай хамрагдаж тэтгэлэгийн эзэд болж чадсан юм. Энэ бүх амжилтын ард сурагчидаа ямагт дэмжиж, чиглүүлж, бэдлэж ажилласан багш нарын асар их хөдөлмөр багтаж буй билээ.



Герман хэлний A1 - ДСД2 шалгалтын үзүүлэлтүүд

